

**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ
2023 ОНД ХЯНАЛТАД АВАГДСАН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
(2023 оны жилийн эцсийн байдлаар)**

2023 оны 12 дугаар сарын 28

Багахангай дүүрэг

Д/д	Зүйл, заалт	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ (хүчингүй болсон хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширсан шалтгаан	Үнэлгээ хувь
1	2	3	4		6	7
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ						
1	<p>1.Орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p> <p>2.Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p> <p>Энэ тогтоолын 10-т заасан Ажлын хэсгийн үйл ажиллагаанд идэвх, санаачилгатай, байнга оролцож</p>	<p>Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022.11.23 №419</p>	<p>1.Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2023 оны 01 дүгээр сараас 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд Улаанбаатар хотоос Багахангай дүүрэгт нийт 218 иргэн шилжин суурьшсан ба тус хугацаанд нийслэлийн бусад дүүрэг, хөдөө орон нутаг руу 253 иргэн шилжин явсан байна. Энэ нь тогтоол гарсан үеийн хүн амын статистик тоон мэдээтэй харьцуулахад Багахангай дүүрэгт хүн амын өсөлтгүй байна.</p> <p>2. Хүн амын тоог 20 хувиар нэмэгдүүлэх бодлогын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын 2023 оны А/64 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. ✓ 2023 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулсан Хөдөөгийн сэргэлт-Хөгжлийн нүүдэл онол, хандлага, сорилт, боломж сэдэвт эрдэм шинжилгээний хуралд дүүргийн дэд 	-	-	70

ажиллахыг Ажлын хэсэгт орсон дэд сайд, аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч нарт тус тус үүрэг болгосугай.

- ажлын хэсгийн дарга хамрагдсан.
- ✓ 2023 оны 05 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд Хөдөөгийн сэргэлт ажлын хэсэг, НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллага, төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн хамтран зохион байгуулсан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, шилжилт хөдөлгөөний мэдээлэл хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, асуудал хариуцсан мэргэжилтэн нар хамрагдсан.
- ✓ Ажлын хэсгийн зүгээс нийслэлээс тус дүүрэгт шилжин ирэх сонирхолтой 19 иргэнд шаардлагатай мэдээллийг өгсөн.
- ✓ Дүүргийн сайтад “Нээлттэй Багахангай” цэс үүсгэж дүүргийн үүсэл хөгжлийн түүх, төр хувийн хэвшлийн байгууллагад байгаа нээлттэй ажлын байрны мэдээлэл, газар зохион байгуулалтын мэдээллийг агуулсан 3 дэд цэсийг үүсгэж мэдээлэл оруулаад байна. Цаашид дэд цэсийг нэмэгдүүлж баяжилтыг тухай бүр хийхээр ажиллаж байна.
- ✓ “Хот хөдөөгийн сэргэлтийн бодлого-2023” видео шторк бэлтгэж ЗДТГ-ын фэйсбүүк хуудсаар сурталчлан ажиллаж “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээнд танилцуулсан.
- ✓ Ажлын хэсгийн асуудал хариуцсан мэргэжилтэн ЗДТГ-ын албан хаагчдад болон дүүргийн удирдлагуудад тус бүр 1 удаа, мөн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хурал 2023.10.26-ны өдөр зохион байгуулагдахад МУЗГ-ын 419 дүгээр тогтоолын талаар болон дүүрэгт

тулгамдаж буй асуудал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал дүгнэлтийг танилцуулж мэдээлэл хийв.

- ✓ 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр дүүргийн 2 дугаар хорооны УБ-Чойр чиглэлийн босоо тэнхлэгийн улсын чанартай авто зам дагуу байрлах 5х9 буюу 45 м2 хэмжээтэй самбарт "Нээлттэй Багахангай" мэдээлэл сурталчилгааг байршуулан автомашинтай зорчигч иргэдэд дүүрэгт шилжин суурьших таатай боломж нөхцлийн талаарх мэдээллийг хүргэсэн. Тус ажилд 1.194.200 төгрөг зарцуулсан. (Холбогдох зургийг дор хавсаргав.)
- ✓ Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд дүүргийн ААНБ-уудын албан хаагчдыг шилжүүлж ирэх ажлыг Засаг даргын шуурхайн үүргийн дагуу зохион байгуулж ажилласан. Дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 25 аж ахуйн нэгж, байгууллагад нийт 509 албан хаагч ажиллаж байгаа ба тус дүүрэгт оршин суугчаар бүртгэлтэй албан хаагч-458, 2023 онд шилжин ирсэн албан хаагч-18, шилжиж ирээгүй албан хаагч-27 байна. Шилжиж ирээгүй албан хаагчдын хувьд эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар тус дүүрэгт шилжих боломжгүй байна.
- ✓ Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төр, хувийн хэвшлийн компани түншлэлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, уялдаа холбоог сайжруулах, нийгмийн оролцоо, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр уулзалт зохион байгуулав. Уулзалтад төрийн 12 ААНБ, хувийн хэвшлийн 4 ХХК-ийн

			<p>төлөөлөл 24 иргэн хамрагдав. Багахангайн үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГ-т нэгжээр орсон компаниудын үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу эхэлснээр шинээр 500-570 ажлын байр бий болох тооцоололтой байна.</p> <p>Хэрэгжилт 70 хувь</p>			
2	<p>1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, Салбар болон орон нутгийн хүрээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох чиг үүрэг, ажил үйлчилгээний чиглэлийг 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022.09.14 №340</p>	<p>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг дүүргийн хэмжээнд судалж, санал, дүгнэлт боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын орлогч Б.Болормаагаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. Дүүрэгт үйл ажиллагаа эрхлэн явуулж буй Багахангай тохижилт, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж, Илч-Орд ОНӨАТҮГ-уудын өмчийн мэдээллийг батлагдсан хүснэгтийн дагуу гарган НЗДТГ-ын Үйлчилгээний нэгдсэн төвийн Төрийн үйлчилгээ шийдвэрлэлтийн хяналтын ажилтан Г.Халиунд UB ERP-ээр 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хүргэн ажиллалаа. НЗДТГ-т зохион байгуулагдсан мэдээлэл солилцох уулзалтад 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Ажлын хэсгийн нарийн бичиг дарга А.Алтантуяа оролцож мэдээллээр хангагдсан. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төр болон хувийн хэвшлийн компани түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх, уялдаа холбоог сайжруулах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Засаг даргын тамгын газрын хурлын танхимд уулзалт зохион байгуулав. Уулзалтад төрийн 12 ААНБ, хувийн хэвшлийн 4 ХХК-ны 24 хүн хамрагдсан. Дүүрэгт</p>	-	-	70

			дээрх ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлээр үйлчилгээ эрхлэдэг хувийн хэвشلүүд байхгүй байна.			
			Хэрэгжилт 70 хувь			
3	<p>1.Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан энэ тогтоолын хавсралтаар баталсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тогтсугай.</p> <p>2.Авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023.02.08 №49</p>	<p>Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан дүүрэгт “Шүүр”, “Шил”, “Шүгэл” ажиллагааг амжилттай зохион байгуулж байна.</p> <p>“Шүүр” ажиллагааны хүрээнд дүүргийн Засаг даргын 2023 оны А/63 дугаар захирамжаар 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан дүүргийн Төрийн болон Орон нутгийн өмчит нийт 24 байгууллагын хамруулан хяналт шалгалт зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд тусгай шалгалт өгч томилогдоогүй 1удирдах, 2 гүйцэтгэх албан тушаалтныг ажлаас чөлөөлсөн байна.</p> <p>“Шил” ажиллагааны хүрээнд МУ-ын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаа. Үүнд: Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, 2008 оноос хойших газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан шийдвэрийн талаарх мэдээллийг бэлтгэн дүүргийн веб сайтад байршуулан олон нийтийг мэдээллээр ханган ажиллаа.</p> <p>“Шүгэл” ажиллагааны хүрээнд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 10 төрлийн видео контент, постер, 150ш шторк, 200ш стейкэрийг дүүргийн веб сайт, байгууллагын фейсбүүк хуудас, гудамж талбайд байршуулан сурталчлан ажиллав. Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Авлигын эсрэг хуулийг сурталчлах 2 төрлийн гарын авлага, 2 төрлийн постер бэлтгэн 60 гаруй иргэдэд хүргэв. Мөн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан “Мэдье, Нэгдье” аянд</p>	-	-	100

			нийслэлийн хэмжээнд 3 байранд шалгарав. Хэрэгжилт 90 хувь			
4	1.Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг (Багануур, Багахангай)-т анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, Төвлөрлийг сааруулах хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих 1 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан санхүүжүүлэх,	2023.02.08 №68	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд гарсан 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 68 дугаар тогтоолын дагуу дүүргийн Хаан болон Төрийн банкны салбар тооцооны төвөөс тодорхой журмын шаардлага ханган хүсэлт ирүүлж, судлагдсан иргэдэд 3 хувийн хүүтэй орон сууцны ипотекийн зээлийг олгож эхлээд байна.. Хэрэгжилт 70 хувь	-	-	70
5	1.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төвсийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай 2023.03.01 №79	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/728 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх Ажлын хэсэг байгуулах тухай" дүүргийн Засаг даргын 2023 оны А/185 дугаар захирамжаар 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулав. Ажлын хэсгийн хурлыг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулан "Дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалтыг ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн 2023 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөө"-г 4 бүрэг 15 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаа. Тус ажлын хүрээнд Нийслэлийн Хөдөлмөр, Халамжийн газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Г.Ганбаяр, Г.Хуягбаатар, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Б.Мөнхбаттай хамтран дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа "Хангайнганэрдэнэ"	-	-	100

			ХХК, "Монгол 8888" ХХК, "Синвоюань" ХХК –д 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр хяналт шалгалт зохион байгуулж холбогдох үүрэг чиглэл өгч ажиллалаа. Шалгалтын хүрээнд 6 зөрчил илрүүлж, 1 албан шаардлага хүргүүлэн, 3.0 сая төгрөгөөр торгосон байна. Хэрэгжилт 90 хувь			
6	1.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2023.04.05 №119	Монгол улсын Засгийн газрын 2023 оны 04 сарын 05-ны өдрийн Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган цэргийн албыг хүндэтгэн үзэх шалтгаанаар биечлэн хаах боломжгүй цэргийн үүрэгтнийг тус тогтоолын дагуу мөнгөн төлбөрөөр орлуулан хаалгав. 2023 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 11,935,308 (арван нэгэн сая есөн зуун гучин таван мянга гурван зуун найман) төгрөгөөр тогтоосон байна. Хэрэгжилт 100 хувь	-	-	100
Дундаж хувь 81,7						
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ						
7	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, санал бодлыг сонсох ажлын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгав.	20 дугаар тэмдэглэлд: 2023.05.09	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах хүрээнд тус дүүргээс Улсын их хуралд гишүүнээр сонгогдсон Ц.Сандаг-Очир, болон нийслэл, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч С.Эрдэнэбаяр нар 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр дүүргийн иргэдтэй уулзалтыг зохион байгуулав. Энэхүү уулзалтын зохион байгуулалтад ЗДТГ-аас тусгайлсан хөтөлбөр гарган дүүргийн Засаг даргаар батлуулж ажилласан ба иргэд, ТББ, ОНӨААТҮГ-ын ажилтан, албан хаагч, төрийн байгууллагын ажилтан, албан хаагчидтай тус тус уулзалтыг зохион байгууллаа. Мөн Улсын их хурал гишүүнЦ.Сандаг-Очир, ХНХЯ-ны дэд сайдын ажлын хэсэг 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдөр дүүргийн иргэдэд	-	-	100

			нийгмийн даатгалын ерөнхий хууль, НДС-гаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, НДС-гаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудын танилцуулгыг хийлээ. Хэрэгжилт 100 хувь			
8	Төрийн өмчит хуулийн этгээдүүдийг нэгтгэх, нийлүүлэх, компанийн хэлбэрт шилжүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдүүдийн ажилтнуудын тоог зохистой түвшинд байлгах	37 дугаар тэмдэглэлд: 2023.09.13	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас үйл ажиллагааны чиглэлийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах замаар компанийн өөр хэлбэрт шилжүүлэх хуулийн этгээд байхгүй талаарх мэдээллийг гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн. Хэрэгжилт 50	-	-	-
Дундаж хувь 100						
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР						
9	1.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цалин хөлс, урамшууллын дүн, холбогдох цахим шуудангийн хаягийн мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2008 оноос хойших шийдвэрийн талаарх мэдээллийг нэгтгэн хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд	“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023.04.17 №01	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/90 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. НӨХГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 5/437 дугаар албан бичгээр удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилогдсон шийдвэр, цалин хөлс, урамшууллын дүн, ажлын байрны тодорхойлолт, 2022 оны санхүүгийн орлого зарлага, холбогдох цахим шуудангийн мэдээллийг хүргүүлсэн. Одоогийн байдлаар Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ байхгүй байна. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/40 дүгээр тогтоолоор батлагдсан 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, төлөвлөгөөний тодотгол, газартай холбоотой 22 үйлчилгээний бүрдүүлэх материалын жагсаалт, газар эзэмших, ашиглах	-	-	100

	<p>нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.</p>		<p>эрхийн дуудлага худалдааны талаар мэдээллийг бэлтгэн https://bagakhangai.ub.gov.mn/ сайтад байршуулан ажилласан. Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, 2008 оноос хойших газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан шийдвэрийн талаарх мэдээллийг бэлтгэн дүүргийн веб сайтад байршуулан олон нийтийг мэдээллээр ханган ажиллаа. Хэрэгжилт 90 хувь</p>			
Дундаж хувь 90						
МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР						
10	<p>Тарваган тахал өвчний хяналт, сэргийлэлтийн арга хэмжээг эрчимжүүлж, шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллахыг үүрэг болгож байна. Үүнд:</p> <p>Нэг. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:</p> <p>1.1. Тарваган тахал болон бусад зоонозын халдварт өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах;</p> <p>1.2. Тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед ажиллах салбар хоорондын багийг томилж сургаж дадлагажуулах;</p> <p>1.3. Тарваган тахлын байгалийн голомтын тандалт судалгаа, дархлаажуулалт урьдчилан сэргийлэлт, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлэх;</p> <p>1.4. Хууль бус ан агнуур, тарвага, тарваганы гаралтай түүхий</p>	<p>Тарваган тахал өвчний хяналт, сэргийлэлтийн арга хэмжээг эрчимжүүлэх тухай 2023.07.06 №05</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн "Тарваган тахал болон хүн, мал амьтны гоц халдварт өвчөөс урьдчилан сэргийлэх тухай" А/1051 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж дүүргийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн "Тарваган тахал болон хүн, мал амьтны гоц халдварт өвчөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай" А/175 дугаар захирамжийг батлуулж замын цагдаагийн постод холбогдох мэргэжлийн байгууллага 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллалаа. Замын цагдаагийн хяналтын постод Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Мал эмнэлгийн албаны ажилтан алба хаагчид 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хяналт шалгалт хийж Улаанбаатар хотруу нэвтэрсэн 7843 тээврийн хэрэгсэлд үзлэг хийж 13012 иргэнд мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөө өгч гарал үүслийн бичиггүй мал болон малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэж явсан 2 зөрчлийг илрүүлэн нийслэлийн Мал эмнэлгийн улсын байцаагчид хүлээлгэн өгсөн. Хөдөлгөөнт</p>			100

<p>эдийн худалдаа, тээвэрлэлтэд хяналт тавих мэргэжлийн байгууллагуудыг үүрэгжүүлэх;</p> <p>1.5. Тарваган тахлын сэжигтэй тохиолдлын голомтыг хязгаарлах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах;</p> <p>1.6. Нийгмийн сүлжээнд тарваганы түүхий мах, эд, эрхтэнг хэрэглэхгүй байх, хууль бусаар тарвага агнах, худалдаалахтай холбоотой мэдээллийг хянаж, таслан зогсоох;</p> <p>1.7. Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоон дахь хяналтыг сайжруулах;</p> <p>1.8. Тарваган тахлын байгалийн голомт өндөр идэвхтэй байгаа аймаг, сумдын голомтын эрсдэлийг бууруулахад мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлын санхүүжилтийг шийдэх;</p>		<p>эргүүлээр батлагдсан хуваарийн дагуу 9 удаа хяналт шалгалтыг зохион байгуулахад тарвага болон тэдгээрийн түүхий эд хориотой хориотой зүйл илрээгүй бөгөөд урьдчилан сэргийлэх ажилд 603.000 төгрөг, шатахуунд 642.600 төгрөг нийт 1.245,600 төгрөгийг зарцуулав.</p> <p>Дүүргийн Эрүүл мэндийн төв нь 14 хоног тутамд нийслэлийн Эрүүл мэндийн газарт төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлэн ажилласан ба Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах чиглэлээр өвчтөн тусгаарлах өрөө, нэг удаагийн хувцас, хамгаалах хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн ажилласан байна. Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, илрэх шинж тэмдэг, халдварлах арга зам сэдвүүдээр иргэдэд мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор байгууллагын цахим хуудсанд 3 удаа мэдээлэл байршуулж, 1689 хандалт авсан байна.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>			
---	--	--	--	--	--

Дундаж хувь 100

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

<p>11</p> <p>1.2.Нутгийн захиргааны болон бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага албан тушаалтанд: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага бүр өмчийн хэлбэр үл хамааран хүний эрхийг хангах, хамгаалахад бүхий л үйл ажиллагааг чиглүүлж тухайн байгууллагын орчны тохижилт, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, стандартын шаардлагыг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, насанд хүрээгүй хүүхэд зэрэг онцгой анхаарал халамж</p>	<p>Хүний эрхийг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2022.12.02 №119</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2023 оны А/69 дүгээр захирамжаар орчны аюулгүй байдлыг хангах, үзлэг шалгалт зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, хяналт шалгалт хийх нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 20 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаа.</p> <p>Хяналт шалгалтыг 1, 2 дугаар хорооны, үйлдвэр, нийтийн эзэмшлийн гудамж, зам</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>100</p>
---	--	--	----------	----------	------------

	шаардах иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангасан байх.		<p>талбай, тоглоомын талбай, сургууль цэцэрлэгийн орчинд зохион байгуулахад нийт 17 зөрчил илрүүлж, холбогдох байгууллагуудад зөрчлийг арилгах тухай албан бичиг хүргүүлэн зөрчлийг арилгуулж ажиллаа.</p> <p>Мөн Хотын стандарт хяналтын газартай хамтран “Хотын стандартын хэрэглээ, үр нөлөө” сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад дэд ажлын хэсгийн гишүүд, дэд бүтцийн байгууллагын ажилтан албан хаагч, худалдаа үйлчилгээний байгууллагын төлөөлөл, хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нар нийт 40 хүн хамрагдав.</p> <p>Дүүрэгт 2022 онд гүйцэтгэл хангалтгүй хийгдсэн явган замын 100м2 талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөтөч хавтан сольж ажилласан. Хэрэгжилт 90 хувь</p>			
12	2.Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарт хамрагдсан мал бүхий иргэдийг 2023 оны III улиралд багтаан шилжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэн холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг батлах тухай 2023.06.21 № 62	<p>Багахангай дүүрэгт 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар хориглосон бүсэд малчин, мал бүхийн 46 өрхийн нийт 1529 мал байснаас 2023 оны жилийн эцсийн байдлаар 19 өрхийн 1328 малыг гаргаж, хэрэгжилт 86.8 хувьтай байна. УБЗАА-наас 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр 01/1629 тоот албан бичгээр ирүүлсэн Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн мал, амьтныг түр саатуулах журмын төсөлтэй танилцаж, тусгах саналыг төлөвлөн 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр УБЗАА-ны Хүнсний хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Сэргэлэнбаатар)-д хаягаар хүргүүлсэн. Хэрэгжилт 86,6 хувь</p>	-	-	70
Дундаж хувь 88,3						
НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР						

13	<p>Хоёр.Дүүргүүдийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:</p> <p>Дүүргийн хэмжээнд шар усны үер болон хөрсний халиа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн хэрэгжилтийг ханган ажиллах.</p>	<p>“Шар усны үер болон хөрсний халиа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай 2023.02.24 01</p>	<p>Багахангай дүүргийн Засаг даргын тамгын газар, Багахангай тохижилт ОНӨААТҮГ-тай хамтран аж ахуйн нэгж, байгууллага, гудамж зам талбай, ард иргэдийг болзошгүй шар усны үерээс урьдчилан сэргийлэх, тусгай зориулалтын автомашин, тээврийн хэрэгсэл чөлөөтэй зорчих нөхцлийг бүрдүүлэх, гэр хороололд хунгарласан цасыг ковш трактораар түрж цэвэрлэх, үерийн далан шуудуунд овоорсон хог хаягдлыг цэвэрлэж, үерийн ус чөлөөтэй урсах нөхцлийг бүрдүүлэх, ус зайлуулах сувгийг нээх болон дүүргийн төв замруу үерийн ус орохоос урьдчилан сэргийлж усыг соруулах, усны урсгалыг өөрчлөх зэрэг шат дараатай ажлуудыг зохион байгуулсан.</p> <p>Үерийн хамгаалалтын далан, замын ус зайлуулах зориулалтын инженерийн байгууламжид 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдөр, 4 дүгээр сарын 12-ны өдрүүдэд 2 удаа үзлэг, шалгалт зохион байгуулсан.</p> <p>Багахангай тохижилт ОНӨААТҮГ-аар газрын даргад хүргүүлсэн үүргийн дагуу тус аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд 1 дүгээр хорооны 650 метр үерийн суваг, дүүргийн төв зам дагуух 350 метр үерийн далангийн хог, хаягдлыг 4 удаа цэвэрлэн шар ус, үерийн ус чөлөөтэй урсах нөхцөл бололцоог хангасан.</p> <p>Багахангай дүүргийн 1, 2 дугаар хорооны айл өрхүүдэд шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлгийг 1 удаа хүргүүлж 76 айл өрх 188 иргэнд 76 ширхэг урьдчилан сэргийлэх гарын авлага материал хүргүүлсэн. Дүүргийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын болзошгүй гамшгийн үед ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгаанд 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр тодотгол хийсэн. Багц</p>	-	-	100
----	--	---	---	---	---	-----

			<p>мессежээр 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдөр 75 иргэнд шар усны үерээс урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэсэн.</p> <p>Тээврийн хэрэгслийн жолооч, иргэдэд гол мөрөн, нуурын мөсөн дээгүүр зорчихгүй байх талаар 3 удаагийн сэрэмжлүүлэг мэдээллийг цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэсэн.</p> <p>Шар усны үерээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг хүргэх зорилгоор "Багахангай Онцгой байдлын хэлтэс" цахим хуудсанд 2 мэдээлэл, фэйсбүүк хуудсанд 12 мэдээ, мэдээлэл байршуулж иргэд олон нийтэд хүргэсэн.</p> <p>Дүүргийн хэмжээнд урсгал ус, гол байдаггүй мөн уулын ам, бэл, гуу жалга дагуу нутагладаг малчин айл өрх байхгүй, үерийн ус зайлуулах далан сувгийн ойролцоо суурьшсан айл өрх, аж ахуйн нэгж байхгүй.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>			
14	<p>Хоёр.Дүүргүүдийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:</p> <p>2.1 Мал амьтны халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаас үзүүлж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх,</p> <p>3.2 Харьяалах нутаг дэвсгэртээ отор нүүдэл хийх, дамжин өнгөрөх мал амьтны шилжилт хөдөлгөөний үед зөвлөн туслах, заавар зөвлөмж өгч хяналт тавих үүрэг бүхий хяналтын цэгүүдийг ажиллуулах, ирсэн тохиолдолд мал эмнэлгийн үзлэг хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах,</p> <p>3.3 Монгол Улсын Шадар сайдын</p>	<p>Мал амьтны халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай 2023.03.21 02</p>	<p>Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт ажилд нийтдээ 10 нэр төрлийн вакцинжуулалтанд 14700 толгой мал, амьтаныг хамруулахаас, тус 10 вакцинжуулалтанд 14879 толгой мал, амьтныг хамруулж 100%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Мөн батлагдсан төлөвлөгөөний дагуу бруцеллэз өвчний тандалтанд 115 эцэг малын цусны дээж, Шүлхий, Бог малын мялзан өвчний тархалтын хувийг тогтоох өвчнөөс эрүүл эсэхийг тогтоох тандалтын ажил зохион байгуулж санамсаргүй түүврийн аргаар 3 өрхийн үхэр12, хонь 18, ямаа 18 нийт 48 дээжийг авч Нийслэлийн мал эмнэлгийн лабораторид хүргүүлсэн бөгөөд шинжилгээний хариу бүгд сөрөг дүнтэй байлаа.</p> <p>Мөн сүүнд бруцеллэз өвчний халдварлалтын түвшин тогтоох ажлыг зохион байгуулж 300</p>	-	-	100

100	-	-	<p>Үнэний сүүнд цагааран урвалын шинжилгээ хийсэн. Шинжилгээний харуу бүгд сөрөг дүнтэй байлаа.</p> <p>Малчдад гоц халдварт, халдварт өвчний талаар мэдээлэл өгөх, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулан, мал эмнэлгийн гэрчлэгээгүй амьд мал тээвэрлэсэн, туварласан тохиолдолд зохих арга хэмжээг авч ажиллах хүрээнд дүүргийн Засаг даргын "Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах тухай А/09 дүгээр захирамжийн дагуу гоц халдварт өвчин гарсан аймаг, сумдаас ирэх, дамжин өнгөрөх мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж мал эмнэлгийн гэрчлэгээнд хяналт тавьж мал, амьтны халдварт өвчин гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллалаа.</p> <p>Дүүргийн Онцгой байдлын хэлтэс болон Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн Хөдөө аж ахуйн тасгаас цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг олон нийтэд хүргэх, цаг агаарын аюулт үзэгдлийн үед дүүдлгараар ажиллах томилоот гамшаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж дүүргийн цахим хуудас, холбогдох байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд хүргэн ажиглалаа.</p> <p>Хэрэжллт 100 хувь</p>	<p>Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай</p>	<p>Нэг. Дүүргийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нар: 1.1. Ногоон бүсэд 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр, 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны</p>	15
					<p>2023 оны өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюлгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хэрэгжилтийг хангах, 3.4 Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг олон нийтэд хүргэх, цаг агаарын аюулт үзэгдлийн үед дүүдлгараар ажиллах томилоот гамшаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах, 4.1 Дүүргийн төвөөс алслагдсан болон отор нүүдэл хийж буй малчин болон мал бүхий иргэдээ эржж, санал хүсэлтийг нь сонсон шаардлагатай тохиолдолд хөнгөлөлтэй үнээр өвс тэжээл, хүнсний дамжлаг үзүүлэх ажлыг зохион байгуулах,</p>	

	<p>өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд байгалийн дагалдах баялгийг ашиглах, амралт, зугаалга зохион байгуулах болон галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглогдоогүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглох арга хэмжээ авах;</p> <p>2.3.ОЙ, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж, ногоон бүсэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийг ойн түймэртэй тэмцэх сургалтад хамруулан, ойн түймэр унтраах ажиллагаанд оролцуулан хавар, намрын улиралд нутгийн иргэдээс урамшуулалт эргүүлийг гэрээгээр ажиллуулан, байнгын хяналт тавьж ажиллах;</p> <p>2.5.Хил залгаа сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргатай "Ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, харилцан ажиллах төлөвлөгөө"- г шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангах;</p>	<p>2023.03.27 03</p>	<p>захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.</p> <p>Ногоон бүсэд байрлалтай 12 аж ахуйн нэгжийн барилга байгууламжид хяналт шалгалт зохион байгуулж 57 зөрчил илрүүлэн, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага-7, мэдэгдэл 2 тус тус хүргүүлсэн.</p> <p>Багахангай дүүргийн 1, 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт бэлтгэл ээлжийн давхардсан тоогоор 374 алба хаагч тал, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүлээр Уаз-фургон автомашинаар нийт 56 удаа 1420 гаруй км-т эргүүлээр ажиллаж малчин өрхийн нийт давхардсан тоогоор 174 айл өрхийн 473 иргэнд санамж сэрэмжлүүлэг хүргэж 174 ширхэг гарын авлага хүргүүлсэн. Малчин болон мал бүхий давхардсан тоогоор 525 айл өрхөд 7 удаа багц мессежээр сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэж ажилласан.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>			
16	<p>Дөрөв. Дүүргүүдийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт.</p> <p>4.1.Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх.</p> <p>5.1. "Тарваган тахал болон хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/862 дугаар захирамжийн</p>	<p>Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай 2023.08.05 № 04</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн "Тарваган тахал болон хүн, мал амьтны гоц халдварт өвчөөс урьдчилан сэргийлэх тухай" А/1051 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж дүүргийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/175 дугаар "Тарваган тахал болон хүн, мал амьтны гоц халдварт өвчөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай" захирамжийг батлуулж замын цагдаагийн постонд холбогдох мэргэжлийн байгууллага 24 цагаар үүрэг гүйцэтгэн</p>	-	-	100

	<p>хэрэгжилтийг ханган холбогдох шийдвэрийг гаргах;</p> <p>5.2.Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг олон нийтэд хүргэх, дуудлагаар ажиллах томилгоот гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах;</p> <p>5.3.Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль бус ан агнуур, тарвага, тарваганы гаралтай түүхий эдийн худалдаа, тээвэрлэлтэд хамтарсан хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах;</p> <p>5.4.Нутгийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагын ажилтан, алба хаагчдад "Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний талаар чадавхжуулах дадлага, сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.</p>		<p>ажилласан.</p> <p>Замын цагдаагийн хяналтын постонд Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Мал эмнэлгийн албаны ажилтан алба хаагчид 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хяналт шалгалт хийж Улаанбаатар хотруу нэвтэрсэн 7843 тээврийн хэрэгсэлд үзлэг хийж 13012 иргэнд мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>Хөдөлгөөнт эргүүлээр батлагдсан хуваарийн дагуу 9 удаа хяналт шалгалтыг зохион байгуулахад тарвага болон тэдгээрийн түүхий эд хориотой хориотой зүйл илрээгүй болно. Урьдчилан сэргийлэх ажилд 603,000 төгрөг, шатахуунд 642,600 төгрөг нийт 1,245,600 төгрөгийг зарцуулж ажилласан.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>			
--	---	--	---	--	--	--

Дундаж хувь 100

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

17	<p>Нийслэлийн хөгжлийн 2023 оны хэрэгжилтийг хангах, он дамжсан удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов" гэжээ.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд:</p>	<p>Нийслэлийн хөгжлийн он дамжсан удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг хангах, 2023 оны арга хэмжээний хэрэгжилтийг хангуулахаар дүүрэг хариуцан хэрэгжүүлэх заалтуудыг түүвэрлэн хэлтэс, алба, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 85 заалтын хэрэгжилтийг ханган 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар хэрэгжилт 52.2 хувьтай, 2 дугаар улирлын байдлаар хэрэгжилт 74.5 хувьтай, жилийн эцсийн байдлаар 100 хувийн хэрэгжилттэй 50, 90 хувийн хэрэгжилттэй 17, 70 хувийн хэрэгжилттэй 7, 30 хувийн хэрэгжилттэй 8, үнэлэх боломжгүй 3</p>	-	-	100
----	--	---	---	---	---	-----

			арга хэмжээ буюу ерөнхий үнэлгээ 88.5 хувьтай "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдэв. Хэрэгжилт 88,5 хувь			
18	"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн оны хэрэгжилтийг хангаж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов" гэжээ.	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд;	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2023 онд дүүрэгт авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр төсөв шийдэгдэж, төлөвлөгөөнд тусгагдсан ажил байхгүй ба тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны үеэр НЗДТГ-ын холбогдох мэргэжилтнээс түүвэр ирүүлж авахаар мэдээллэсэн. Хэрэгжилт -	-	-	-
19	"Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд явц удаашралтай, он дамжин хэрэгжиж байгаа арга хэмжээнүүдийг эрчимжүүлж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад;	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд;	Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний 61 заалтын хэрэгжилтийг ханган 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар хэрэгжилт 68.4 хувьтай, 2 дугаар улирлын байдлаар хэрэгжилт 82.7 хувьтай, жилийн эцсийн байдлаар 100 хувийн хэрэгжилттэй 40, 90 хувийн хэрэгжилттэй 13, 70 хувийн хэрэгжилттэй 1, 30 хувийн хэрэгжилттэй 3, үнэлэх боломжгүй 4 арга хэмжээ буюу ерөнхий үнэлгээ 95.1 хувьтай "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдэв. Хэрэгжилт 95.1 хувь	-	-	100
20	Зам, тээврийн нэгдсэн системд шаардлагатай бодит мэдээ мэдээллийг түргэн шуурхай гаргах, системүүдийг нэгтгэж холбоход дэмжлэг үзүүлж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад;	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлд;	Замын хөдөлгөөний нэгдсэн систем (RFID) техникийн хяналтын цахим гэрчилгээний талаар Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга О.Чинзориг (99080387)-той холбогдож тодруулахад цахим гэрчилгээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамнаас нэгдсэн чиглэл гарах хүртэл тус дүүрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ байхгүй талаар хариу өгсөн. Дүүргийн зүгээс тодорхой чиглэл ирсний дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар	-	-	70

			төлөвлөөд байна. Хэрэгжилт 70			
21	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад;	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлд:	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 7 заалтын хэрэгжилтийг ханган 2023 оны 03-11 дүгээр саруудад нийт 9 удаа биелэлтийг нэгтгэн тайлагнаж жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 77.1 хувьтай байна. Тус төлөвлөгөөнд тусгагдсан дүүрэгт хэрэгжих томоохон ажлаас дурьдвал: Дүүргийн Соёлын ордны барилгын нийт төсөвт өртөг 5.2 тэрбум төгрөг ба 2023 онд Нийслэлийн төсөвт 300.0 сая төгрөг тусгагдав. Тус барилгын ажил 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлж өнгөрсөн онд хийж гүйцэтгээгүй дутуу ажлуудыг хийж, дүүргээс 3, НХОГ-аас 1 удаагийн хяналт тавив. Тайлангийн хугацаанд дүүргийн удирдлагууд барилгын гүйцэтгэгч нартай 2 удаагийн уулзалт зохион байгуулж үүрэг чиглэл өгч ажиллалаа. Мөн барилгын төсвийн үлдэгдэл болох 4,2 тэрбум төгрөгийг Нийслэлийн 2024 оны төсөвт бүрэн суулгаж өгөх саналыг НЗДТГ, НСУГ-т дүүргийн Засаг даргын 2023 оны 1/862 тоот албан бичгээр хүргүүлэв. Түүнчлэн Нийслэлийн 2024 оны төсвийн төслийн хэлэлцүүлэгт тус саналыг уламжилж 2,3 тэрбум төгрөгийг тусгуулаад байна. Хэрэгжилт 77.1	-	-	70
22	"Хэсгийн ахлагчийн систем"-ийн үйл ажиллагааг одоо мөрдөгдөж буй "Хэсгийн ахлагч нарын ажиллах нийтлэг журам"-д нийцүүлж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт; "Хэсгийн ахлагчийн систем"-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж жигдрүүлж нутагшуулах ажлыг зохион байгуулах, хэсгийн ахлагч нарын гар утасны интернэтийн зардлыг санхүүжүүлж ажиллахыг дүүргийн	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр хуралдааны тэмдэглэлд:	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газраас дэвшүүлсэн "Цахим үндэстэн" болох зорилт, нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд "ДИЖИТАЛ СИТИ" төслийг хэрэгжүүлэх хүрээнд хороодын хэсгийн ахлагч нарын гар утсанд "Дижитал УБ" аппликейшныг суулгуулан ажиллаж байна. Тус хөтөлбөрийн дагуу хэсгийн ахлагч нар болон хорооны мэргэжилтнүүд цахимаар сургалтад хамрагдан "Хэсгийн ахлагчийн систем"-ийг	-	-	100

Засаг дарга нарт;
Хэсгийн ахлагчийн системд байршуулах мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг дүүрэг, хороодын Засаг дарга нарт;

хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллан тус системд нэвтрэн орж зөрчил, мэдээлэл шивэх боломжгүй байсныг Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлж хэвийн ажиллагаанд шилжин ажиллаж байна. Одоогоор хэсгийн ахлагч нар 2023 оны сарын тайлан, зөрчил зэргийг шивж оруулан баталгаажуулаад байна.
Хэрэгжилт 90 хувь


Дундаж хувь 84,1


БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ 92,0


ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ ХУВЬ 91,0

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА:  Л.САНЖИЙЖАМЦ



ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА:  Б.ОТГОНЖАРГАЛ



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН:  Н.БАТЦЭНГЭЛ